



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/270

Есөнбулаг сум

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд,
иргэдийн анхдугаар зөвлөгөөнийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалт, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэг, "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 7.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Алтай аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, үйлчилгээг үзүүлэх, эцэг эх асран хамгаалагчдад зөвлөн туслах, иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, аймаг болон сумдад амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд, иргэдэд сэргээн засах, хамгаалах, нөхөн сэргээх цогц үйлчилгээг үзүүлж, хүүхдүүдийн эцэг, эх асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Хамтын оролцоо-Тэгш боломж" хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулж, үйл ажиллагаанд шаардагдах зардалд дэмжлэг үзүүлж хавсралтаар баталсугай.

2. Зөвлөгөөнд шаардагдах 7,045,000 (долоон сая дөчин таван мянган) төгрөгийг Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар) Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг) -т тус тус үүрэг болгосугай даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ



D:zahiramjZax ZD 2026

8200010497

Аймгийн Засаг даргын 2026 оны
... дугаар сарын 15 -ны өдрийн /15/ дүгээр
захирамжийн хавсралт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД, ИРГЭДИЙН
АНХДУГААР ЗӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛАХ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ

№	Зардлын утга	Тоо ширхэг	Км, хоног	Нэгжийн үнэ	Нийт дүн	Хариуцах эзэн
1	Шатахуун Ховд-Гаа-ховд	2(машин) Alphard, жижиг тэрэг	250л (840км)	3200	800.000	АЗДТГ
2	Сургалтын материал	400 хүн	-	3000	1,200,000	АЗДТГ
3	Буудлын өрөө	1(өрөө) 3 ортой	1 хоног	180,000	180,000	АЗДТГ
4	Өглөөний цай Оройн хоол	15 хүн 15 хүн	3 хоног	300,000 675,000	975,000	АЗДТГ
5	Стент, баннер	2ш	-	150,000	300,000	АЗДТГ
6	Сумдаас ирэх хүмүүсийн унааны зардал	60 хүн оролцох	-	-	3,590,000	АЗДТГ
	Нийт дүн 7,045,000					

_ оОо _